

МОНГОЛ УЛС ДАХЬ ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ ГАРСАН ШАЛТГААН

CAUSES OF ROAD ACCIDENT IN MONGOLIA




Ц.ЭРДЭНЭЧИМЭГ Улаанбаатар хотын цагдаагийн газрын Замын цагдаагийн газрын мэдээлэл судалгаа хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч

ERDENECHIMEG TS. Senior officer of Analysis and information of the Traffic Police Department, Department Police of the Ulaanabaatar city, police major

Abstract: Traffic accident and its casualties are being raised by the number of automobiles, trafficjam and breaking traffic regulations. Studying the cause of road accident should be the basis of arranging, planning policy and organizing to prevent traffic accident, to decrease crime against the rule of road safety and its casualties.

“Зам тээврийн осол” - зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь бие, эрүүл мэнд хохирох, тээврийн хэрэгсэл болон замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа болон бусад эд материалын хохирол учрах явдал⁴-ыг хэлнэ.

Зам тээврийн осол гарч буй шалтгаан




Улсын хэмжээнд бүртгэгдсэн 18367 зам тээврийн ослын 17848 буюу 97,2 хувь нь жолоочийн буруугаас, 475 буюу 2,6 хувь нь явган зорчигчийн буруутай үйлдлээс, 44 буюу 0,2 хувь нь замын нөхцлөөс гарсан гэж бүртгэгджээ.

	ЖОЛООЧИЙН		ЯВГАН ЗОРЧИГЧИЙН		ЗАМЫН НӨХЦӨЛ	
	тоо	эзлэх хувь	тоо	эзлэх хувь	тоо	Эзлэх хувь
Нийслэл	14747	97,57%	359	2,4%	4	0,03%
Орон нутаг	3101	95,2%	116	3,6%	40	1,2%
Улсын хэмжээнд	17848	97,2%	475	2,6%	44	0,2%

Жолоочийн буруутай үйлдлээс гарсан зам тээврийн осол, эзлэх хувь

⁴ МУ-ын ЗХДүрэм 1.4 заалтаас

Жолоочийн буруутай үйлдэл дотроо:



2013 онд бүртгэгдэж шалгагдсан зам тээврийн ослын шалтгааныг 2012 оны ослын шалтгаантай харьцуулан үзвэл согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсноос, хурд хэтрүүлснээс, анхаарал болгоомжгүйгээс гарсан ослууд өссөн байхад уулзвар гарц нэвтрэх журам зөрчснөөс, эргэх үйлдэл буруу хийсэн, хажуу хоорондын зай тохируулаагүйгээс гарсан осол тус тус буурсан байна. Зам тээврийн осол гарсан шалтгаанаас согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодон хөдөлгөөнд оролцох явдал буурахгүй, түүнээс үүдсэн хор уршиг арилахгүй байна.

Осол ихээр гарч буй шалтгаан

Улаанбаатар	Орон нутаг
- Хажуу хоорондын зай тохируулаагүй - Анхаарал болгоомжгүй хөдөлгөөнд оролцсон - Уулзвар гарц нэвтрэх журам зөрчсөн - Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон - Ухрах үйлдэл буруу хийсэн	- Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон - Хурд хэтрүүлсэн - Анхаарал болгоомжгүй хөдөлгөөнд оролцсон - Зогсоох арга хэмжээ аваагүй - Уулзвар гарц нэвтрэх журам зөрчсөн

Улаанбаатар хотод замын хөдөлгөөний нягтрал ихтэй үед автомашинууд хажуу хоорондын зай бариагүйгээс мөргөлдөх, шүргэлдэх явдал их байгаагаас гадна согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсоноос зам тээврийн осол гарах шалтгаан буурахгүй өсөх хандлагатай болсон байна.

Орон нутаг согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодон хурд хэтрүүлэх, зогсоох арга хэмжээ авч чадахгүй байх, замын нөхцөлд хурд тохируулан яваагүйгээс онхолдох хэлбэрээр зам тээврийн осол ихээхэн бүртгэгдсэн байна.

Сүүлийн жилүүдийн зам тээврийн ослын статистик үзүүлэлтээс дүгнэлт хийхэд бүртгэгдэж буй зам тээврийн ослын дийлэнх хувь нь жолоочийн буруутай үйлдлээс гарч, хохирлын тоон үзүүлэлтээс явган зорчигч, тээврийн хэрэгслээр зорчигч ихээхэн гэмтсэн нь жолоочийн буруугаас бусад хүмүүс ихээхэн хохирол амсч байгаа учраас хор уршгийг нь харж хариуцлага тооцдог механизм манай улсад нэн тэргүүн хэрэгтэй байгаа юм. Явган зорчигч, тээврийн хэрэгслээр зорчигчийн амь нас, эрүүл мэнд ихээхэн хохирч байна.

Замын хөдөлгөөнд оролцогч хэн бүхэнд замын хөдөлгөөнд зөв оролцох дадлыг тухайн замын хөдөлгөөнд оролцогчдын дадал хэвшил болгох асуудал нэн чухал байгаа юм. Замын хөдөлгөөнд оролцогч хүн бүхэн дүрмээ биелүүлддэг, биелүүлэх ёстой гэсэн сэтгэл зүйтэй байх юм бол зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж, амь насаа алдах, бусдын амь насыг хохироох, эрүүл мэндээрээ хохирох асуудал буурах улмаар цэгцлэгдэх ч магадлалтай юм.

Анхаарал болгоомжгүй хөдөлгөөнд оролцох шалтгаанаас гарсан осол нь 2013 онд бүртгэгдсэн нийт ослын 12,5 хувийг эзэлсэн. Автомашин жолоодон замын хөдөлгөөнд оролцож буй жолооч нь гар утсаар ярих, нүүрээ будах /эмэгтэйчүүд/, тамхи асаах, хүүхэдтэйгээ зууралдах зэргээр анхаарал сарнихад жолоочийн хөдөлгөөн удаашрах, гэрэл дохио анхаарахгүй, эгнээ байр эзлэхдээ бусдыг анзаарахгүй байх, хажуу хоорондын зайг тохируулахгүй зэрэг жолоочийн ур чадварт нөлөөлдөг байна. Ялангуяа залуу жолооч нарт ихээхэн тохиолддог гар утсаар ярьж хөдөлгөөнд оролцох үед жолооч нь чихэвч ашиглаж заншаагүйгээс нэг гараараа жолооны хүрдийг эргүүлснээр осол гарах нөхцлийг бүрдүүлдэг

байна.

Хурд хэтрүүлэх шалтгаанаас гарсан осол нь 2013 онд бүртгэгдсэн нийт ослын 8,1 хувийг эзэлжээ. Хурд хэтрүүлснээс гарсан зам тээврийн ослын хор уршиг нь бусад шалтгаанаас өндөр байдаг. Осол гарах үед автомашины хурд 30 км/цаг түүнээс бага хурдтай байхад осолд өртсөн явган зорчигч /бусад оролцогчид/-ын авсан гэмтэл нь үхэлд хүргэх эрсдэлд хүргэдэггүй. Өөрөөр хэлбэл автошинаар хурд багатай явах тусам хохирол бага учирдаг. Сургууль цэцэрлэгийн орчим зам, нарийн гудамж, явган хүмүүс хөдөлгөөнд ихээр оролцдог замууд түүнчлэн харанхуй гэрэлтүүлэг муутай замуудад хурд багатай явах нь ослын улмаас учрах хохиролд их нөлөөтэй юм. Хурд хэтрүүлэх явдлыг багасгаснаар хурднаас шалтгаалан гарч буй ослыг 8,1 хувь хүртэл бууруулж болох байна. Цагдаагийн байгууллагад хурд хэмжих багаж төхөөрөмж хангалттай байх, хурд хэтрүүлэх магадлалтай газруудад байнгын хяналт тавих зэргээр ажлуудыг зохион байгуулж хурд хэтрүүлэх явдалтай тэмцэх чухал юм.



Согтуугаар үйлдэгдсэн осол нь хор уршиг ихтэй, хохирлын эрсдэл нь өндөртэй гэж дэлхийн улс орнууд үздэг. Архи согтууруулах ундаа нь автомашин жолоодож буй хүний оюун ухаан, жолоодох ур чадвар, самбаачлах хугацаа, оюун санаанд шууд нөлөөлдөг учраас согтолт их байх тусам эрсдэл нь маш өндөр байна гэсэн үг юм. Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үед автомашин жолоодох нь жолооч хурд хэтрүүлэх, гэрэл дохио болон урьдаас ирэх саадыг анзаарахгүй байх, зогсоох арга хэмжээ авч чадахгүй, анхаарал төвлөрөхгүй байх зэргээр өөрийгөө хянах чадварт муугаар нөлөөлж ноцтой зам тээврийн осол гарах үндэс болж байна.

Явган зорчигчийн буруутай үйлдлээс гарсан зам тээврийн осол, эзлэх хувь

Явган зорчигч:

Замаар явган яваа /зам дээр ажил, үүрэг гүйцэтгэж байгаагаас бусад/ хүн. Жагсаалаар яваа болон тахир дутуу хүний тэргэцнэртэй, мөн тэргэ түрж, чарга чирч, мотоцикл, мопед, унадаг дугуйг хөтөлж замаар яваа хүмүүсийг явган зорчигчид хамааруулна.³

Замын хөдөлгөөнд оролцогч:

Замын хөдөлгөөнд оролцогч гэдэг нь замаар яваа жолооч, явган зорчигч болон тээврийн хэрэгсэлээр зорчигчийг хэлнэ.³ Явган зорчигч нь жолоочийн нэгэн адил замны хөдөлгөөнд оролцогч юм.

Явган зорчигчийн буруутай үйлдэл дотроо

- Замын хөдөлгөөний дүрмийг хэрэгжүүлэх биелүүлэх нь бүх нийтэд /эвхэн жолоочид биш/ замны хөдөлгөөнд оролцогч явган зорчигч, тээврийн хэрэгсэлээр зорчигчид хамааралтайг Замын хөдөлгөөний дүрмид заасан.
- Явган хүний гарцын шугам, гарамгүй газраар зам хөндлөн гарах.
 - Гэрлэн дохио зорчиж зам хөндлөн гарах.
 - Ойртон ирж яваа тээврийн хэрэгсэлийн урддур зам хөндлөн гүйх.
 - Зогсож буй автомашины, автобуснаас буугаад урддур нь зам руу орох.
 - Замын зорчих хэсэг дээр буюу зорчих хэсгийн эсрэг дагалж явах.
 - Согтууруулах ундааны зүйл хэрэглэж биеэ авч явах чадваргүй үедээ замны зорчих хэсэг дээр үрхвэх, хэвтэх.
 - Замын голоор тавьсан тусгаарлах хайс, хашлага дээгүүр давах, доогуур нь шугах.
 - Замын хөдөлгөөнд оролцоходоо анхаарал болгоомжгүй оролцох /зам хөндлөн гарахдаа гар утсаар ярих, чихэвчний хөгжим сонсох, мессеж бичих/ зэргээс автомашинд дайрагдаж, мөргөгдөж зам тээврийн осолд өртөх нь их байна.

Явган зорчигчийн буруутай үйлдэлээс шалтгаалсан зам тээврийн ослын хувьд улсын хэмжээнд 475 буюу нийт бүртгэгдсэн ослын 2,6 хувийг эзэлсэн байна. Зөвхөн явган зорчигч мөргөсөн зам тээврийн осолд явган зорчигчийн буруутай үйлдэл нь 19,7 хувийг эзэлж байгаа юм. Түүнчлэн явган зорчигчийн өөрсдийн буруутай /хохирогчийн буруутай/ үйлдлээс гарсан хөнгөн, хүндэвтэр 85 орчим хэргийг

х э р э г с э х г ү й болгосон байна. Явган зорчигч х ү ү х д ү ү д и й н хувьд мөн замны х ө д ө л г ө ө н и й дүрмийн мэдлэг дутмаг байгаагаас шалтгаалан зам тээврийн осолд өртөх тохиолдол гарсаар байна

Н и й с л э л д явган зорчигчдын замны хөдөлгөөнд оролцож байгаад хяналт тавих, тэдний замны х ө д ө л г ө ө н д о р о л ц о х мэдлэг, дадлыг

дээшлүүлэх, жолооч нарт замны хөдөлгөөний дүрмээ биелүүлэх дадал, ухамсар суулгах чиглэлээр сэтгэл зүйн сургалт, мэдээлэл, сурталчилгаа явуулахад анхаарал хандуулах хэрэгтэй байгаа нь 2013 онд нийслэлд замны хөдөлгөөнд оролцож яваад амь нас, эрүүл мэндээрээ хохирсон явган зорчигчийн тоо баримтаас харагдаж байна. Улсын хэмжээнд 2013 оны байдлаар 78 тохиолдолд явган зорчигч биеэ авч явах чадваргүй согтуугаар хөдөлгөөнд оролцож автомашинд дайрагдаж амь нас, эрүүл мэндээрээ хүнд хохирох явдал гарчээ. Энэ тохиолдолууд нь согтуу явган зорчигч зам дээр хэвтэх, унтах, автомашин зогсоох гэж байгаад ойчих, зорчих хэсэг дээр бие засах, гарцгүй газраар автомашины урддур тэнцвэрээ олохгүй гүйж байгаад унах зэргээс гарсан байна.

Замын нөхцөл ба техникийн гэмтлийн улмаас гарсан зам тээврийн осол, эзлэх хувь:

Замын нөхцөл	Замын гадаргуу, нөхцөл	Техникийн гэмтэл саатал: Жолоочоос хамааралгүй техникийн гэмтэл /жолооны хүрд гацах, тоормос гэнэт барихгүй болох, гэрэл дохионы саатал, хөдөлгүүрийн гэмтэл гэх мэт/ үзүүлэлтийг тооцож байна.
	Замын гэрэлтүүлэг, чимэглэл	
	Замын тэмдэг тэмдэглэгээ ойгломжгүй байснаас	
	Бусад	

Замын нөхцөл:

Замыг шинээр барьж байгуулах, засварлахдаа технологийн шаардлагыг чанд мөрдөж иж бүрнээр /замын инженерийн байгууламж, хөдөлгөөн зохицуулах хэрэгсэл гэх мэт/ нь шийдвэрлэж байх шаардлагатай гэж олон улсад үздэг байна. Зам-орчин нь өөрөө замны хөдөлгөөний нэг бүрдэл болдог.

Замын нөхцөлөөс шалтгаалан гарсан осол улсын хэмжээнд 44 бүртгэгдсэний 4 нь нийслэлд, 40 осол орон нутагт бүртгэгдсэн байна. Энэ шалтгаанд техникийн гэмтэл, гадны гэрэл /замын гэрэл/, зам орчны нөхцөл зэргийг багтаан авч үзэж байгаа боловч авто зам, замны байгууламж хариуцсан байгууллагад техникийн акт тавьж арга хэмжээ тооцсон бүртгэл байхгүй байгаагаас замны нөхцөлөөс гарсан ослын үзүүлэлт бага бүртгэгдсэн хэвээр байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдал, шуурхай байх үндсэн нөхцлийн нэг нь зам, замны дэд бүтэц байдаг. Өнөөг хүртэл замны эвдрэл гэмтэл, онгорхой нүх, овоолсон шороо, зузаан мөстсөн замны хэсэг, замны бусад хангалтгүй нөхцөлийг тойрох гэсэн автомашины жолооч хөдөлгөөний чиглэлээ гэнэт өөрчилсөн, тойрч гарахад эсрэг урсгалд орсноос гарсан тохиолдолыг осол гарсан актад тусгахгүй, ихэнхи тохиолдолд бурууг жолооч, бусад хөдөлгөөнд оролцогчдод хариуцуулж байна. Манай орны зам тийм сайн биш байхад замны нөхцөл гэсэн хүснэгтэд байгаа тоон үзүүлэлт маш бага байгаа нь үүнтэй холбоотой юм.

Замын нөхцөлөөс шалтгаалан гарсан Хөдөлгөөний





аюулгүй байдал техник ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас учирсан хохиролыг замын засвар арчилгаа хариуцсан байгууллага, албан тушаалтнаар төлүүлж байх, замын засвар арчлалтын шугамын албадыг шинээр буй болгох тогтолцоо манай улсад хэрэгтэй байгаа нь дээрхи тоо баримтаас харагдана. Замын хөдөлгөөнд оролцогчдод стандартын шаардлага хангасан, аюулгүй зам хэрэгцээтэй байгаа тул замын байгууламж хариуцсан албадад зохих хууль зүйн хариуцлага нь зам, замын нөхцөл нь чанарын өндөр түвшинд хүрэх нэг механизм болно.

Зам тээврийн осол гарах шалтгаанд нөлөөлж буй зарим хүчин зүйлс

Зам тээврийн ослын шалтгаан нөхцлийн судалгааг Замын цагдаагийн газрын Мэдээлэл судалгаанаас гаргахдаа хууль зүйн үр дагавараар нь үнэлгээ хийдэг. Энэ нь жолооч замын хөдөлгөөний хууль дүрмийн ямар зүйл заалтыг зөрчсөн гэдгээр нь тооцоолж зам тээврийн осолд дүгнэлт гаргадаг. Тухайлбал: Зам тээврийн осол үйлдэх үедээ согтуу байсан эсэх, хурдны байдал, анхаарал болгоомжтой явсан эсэх, уулзвар нэвтрэх, зай тохируулах, эргэх үйлдэл болон уулзвар нэвтрэх үйлдэл хийж байсан гэх мэт ангилан авч үздэг. Жолооч замын хөдөлгөөнд оролцож байхдаа, тодруулбал зам тээврийн осол гаргах үедээ анхаарал юунд сарнисан, жолоо барихаас өөр ямар үйлдэл хийж явсан, осол гарахад шууд нөлөөлсөн болон нөлөөлж болох үйлдэл, хүчин зүйлүүд байдаг.

Зам тээврийн осолд холбогдсон жолооч нараас авсан социологийн судалгаанаас гаргасан дүгнэлтээс танилцуулбал:

1. Гадна талын объектууд /явган зорчигч болон бусад жолооч нар/ 27,6 хувь,
2. Гудамж замд байрлуулсан сурталчилгаа, зарын самбар дээрх мэдээллийг уншиж явсанаас 12,5 хувь
3. Хамт явж байгаа зорчигч анхаарал сарниулсанаас 9,5 хувь
4. Автомашины хянах самбар, товчлуур, тохиргоог оролдож явсанаас 3,8 хувь
5. Хөдөлгөөний үед идэж уух зүйл хэрэглэсэнээс 1,9 хувь
6. Гар утсаар ярьсанаас 6,2 хувь
7. Автомашин дотор тамхи татсанаас 1,7 хувь
8. Сэтгэл зүйн таагүй байдлаас шалтгаалж /сэтгэл тавгүй/ анхаарал сарнисанаас 8,4 хувь
9. Бусад тодорхойгүй хүчин зүйлүүд 28,4 хувь нөлөөлсөн байна.

Автомашин жолоодон замын хөдөлгөөнд оролцоход замын хөдөлгөөний дүрмийн заалт зөрчихөөс гадна осол гарахад нөлөөлөх хүчин зүйлсэд судалгаа шинжилгээ хийж түүнд чиглэсэн урьдчилан сэргийлэх ажил, сургалт явуулах шаардлагатай юм.